

ТУЗ-ийн 2023 оны 09-р сарын 12-ны өдрийн
23/001 тоот тогтоолын хавсралт

“МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ” ХХК



F I N A N C E

**ТУЗ-ЫН ДЭРГЭДЭХ ЦАЛИН,
УРАМШУУЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЖУРАМ**

2023 он

ТУЗ-ЫН ДЭРГЭДЭХ ЦАЛИН,
УРАМШУУЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 "МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ" ХХК (цаашид "ББСБ" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо ("Хороо" гэх)-ны журам (цаашид "Журам" гэх)-ээр ББСБ-ын ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг боловсруулах, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах, ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулна.

ХОЁР. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 Хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Хорооны гишүүд болон даргыг ТУЗ-ийн хурлын тогтоолоор томилно.
- 2.2 Хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгоно. ТУЗ-ийн дарга нь Хорооны даргаар ажиллахыг хориглоно.
- 2.3 Хорооны гишүүдийн хоёроос доошгүй гишүүн нь хараат бус гишүүд байна.

ГУРАВ. ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

- 3.1 ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дэргэцэх хороодын нарийн бичгийн даргаар давхар ажиллана.
- 3.2 Хорооны Нарийн бичгийн дарга нь Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх буюу зохион байгуулалтын чиг үүргийг гүйцэтгэнэ.
- 3.3 Хорооны Нарийн бичгийн даргын чиг үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

ДӨРӨВ. ХОРООНЫ ХУРАЛ

- 4.1 Хороо нь жилд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 4.2 Хорооны дарга эсхүл хорооны аль нэг гишүүний хусэлтээр хурлыг зарлан хуралдуулж болно.
- 4.3 Хорооны хуралд хоёроос доошгүй гишүүд ирснээр Хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.
- 4.4 Хорооны хурлаас гарах бүх шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.
- 4.5 Хорооны хурлаас дүгнэлт гарах бөгөөд дүгнэлтэд хуралд оролцсон Хорооны гишүүд гарын үсэг зурна.
- 4.6 Хорооны нарийн бичгийн дарга нь дүгнэлт гарснаас хойш хуанлийн 10 хоногийн дотор ТУЗ-ийн хурлыг хуралдуулж, дүгнэлтийг танилцуулан ТУЗ-ийн тогтоолоор баталгаажуулна.
- 4.7 Хорооны нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд хурлын тэмдэглэлийг баталгаажуулах зорилгоор дууны болон дуу, дүрсний бичлэг хийн хадгалж болно.
- 4.8 Хорооны хурлыг цахим хэлбэрээр явуулах боломжтой.

ТАВ. ХОРООНЫ БҮРЭН ЭРХ

- 5.1 Хороо нь дор дурдсан бүрэн эрхийг эдэлнэ:
- 5.1.1 ББСБ-ын ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

- 5.1.2 Шаардлагатай тохиолдолд гаднын хуулийн болон бусад хараат бус мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг авах.
- 5.2 Хороо нь дор дурьдсан асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах, шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.
- 5.2.1 Гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгох, томилох, чөлөөлөх бодлогын хувьд:
- 5.2.1.1 Гүйцэтгэх удирдлагын аль нэг гишүүн болон Компанийн ажиллагсдаас хорооны нарийн бичгийн даргаар дамжуулан мэдээлэл шаардах
- 5.3 Хороо нь нэр дэвшүүлэх, сонгох, томилох, чөлөөлөх бодлогыг тодорхойлохдоо холбогдох дүрэм журмыг харгалзан дараах үүрэгтэй байна. Үүнд:
- 5.3.1 Хороо нь ТУЗ-д нэр дэвшүүлэх эрх бүхий Компанийн хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлэх тухай санал, нэр дэвшүүлж буй этгээдийн тухай мэдээллийг хүлээн авч тухайн этгээд нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянаад, шалгуур хангахгүй байгаа бол энэ тухай нэр дэвшүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол хараат бус гэдгийг нотлох мэдээлэл, уг мэдээлэл үнэн зөв болох тухай нэр дэвшигчийн баталгаа зэргийг гаргуулсан байна. Эдгээр мэдээлэлд үндэслэн нэр дэвшигчийг саналын хуудсанд оруулах тухай саналаа ТУЗ-ийн хуралд оруулна.
- 5.3.2 ТУЗ-ийн гишүүн нас барсан, удаан хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ТУЗ-ийн ээлжит хурал хүртэлх хугацаагаар нөхөн сонгох гишүүнийн нэрийг дэвшүүлэх асуудлыг хороо хариуцан гүйцэтгэнэ.
- 5.3.3 Хороо нь ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсон үед ТУЗ-ийн гишүүд үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн тухай ТУЗ-ийн гишүүн тус бүрээр дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.
- 5.3.4 ТУЗ-өөс үүрэг болгосон бусад асуудал.

ЗУРГАА. ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ

- 6.1 Хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
- 6.1.1 Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын дээд, болон доод хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд баггаан цалин урамшуулал олгох талаар саналыг боловсруулж, ТУЗ-д оруулах;
- 6.1.2 ТУЗ-ийн дарга, хорооны гишүүн болон бусад зөвлөлийн гишүүдэд ББСБ-аас олгох цалин урамшууллын шалгуурыг гишүүдийн хараат бус байдал нөлөөлөхгүй, өрсөлдөх чадвартай байлгахад боловсруулах;
- 6.1.3 Бүх ажилчдын цалин урамшууллын бодлого боловсруулах чиглэлээр ББСБ-ын удирдлага болон хүний нөөцийн боловсруулсан төсөлд санал өгөх.
- 6.2 Хороо нь цалин, урамшууллын талаарх саналыг боловсруулахдаа холбогдох дүрэм журмыг харгалзан дараах хүчин зүйлсийг анхаарна. Үүнд:
- 6.2.1 Мэргэжлийн шаардлага хангахуйц ур чадвартай ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын мэргэжилтнийг тагах, тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхжүүлэхэд хангалттай цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- 6.2.2 Гүйцэтгэх захиралд ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан олгох урамшуулал нь нийт цалин урамшууллын санд багтаж, ББСБ-ын ашигт үйл ажиллагаатай шууд уялдсан байх;
- 6.2.3 ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоохдоо хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримтлах.
- 6.3 Хороо нь ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин, урамшууллын саналыг боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ДОЛОО. АЖЛЫН ТАЙЛАН

- 7.1 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь Хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүд болон Гүйцэтгэх удирдлагад хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн санал, дүгнэлтийг багтаасан байна.
- 7.1.1 Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн хурал, зөвлөгөөн, семинарт оролцсон ирц, идэвх, санаачлага, ТУЗ, харьяалагдах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлсэн, ажлаа тайлагнасан байдал зэрэг үзүүлэлтийг харгалзан үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 7.1.2 Нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ийн гишүүнийг үүрэгт ажлаа тайлант хугацаанд "хангалтгүй гүйцэтгэсэн" гэж үнэлсэн бол энэ тухай бичгээр гаргасан дүгнэлт, түүнд тухайн гишүүний бичгээр гаргасан тайлбарыг хавсарган ТУЗ-д танилцуулна.
- 7.2 Хороо нь албан үүргийнхээ хүрээнд хийсэн ажлаа ТУЗ-ийн ээлжит хурлаар ТУЗ-д тайлагнана.
- 7.3 Хорооны Нарийн бичгийн дарга нь Хорооны үйл ажиллагаатай холбоотой ББСБ-ын жилийн үйл ажиллагааны тайланд тусгагдах мэдээллийг бэлтгэн тайлан гаргах чиг үүрэг бүхий албан тушаалтанд тухай бүрд нь гарган өгнө.